

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ VI ХУРАЛДААНЫ ШИЙДВЭР

2022 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 07

Арвайхээр сум

Хэлэлцсэн нь

- 1 ТУЗ-ийн хурлын шийдвэрийн хэрэгжилт, үйл ажиллагааны талаар хэлэлцэх
- 2 Захирлын сонгон шалгаруулалтын шалгалт зохион байгуулах талаар хэлэлцэх
- 3 Сорилын шалгалт авах /англи хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалт авах/
- 4 Сорилын дүнгийн үнэлгээ /Англи хэлний мэдлэгийн дүнгийн үнэлгээ/
- 5 Ярилцлага асуумж шалгалт авах
- 6 Ярилцлага асуумжийн үнэлгээ танилцуулах
- 7 Төслийн танилцуулга ярилцлага /Эмнэлэг хөгжүүлэх төслийн ярилцлага/
- 8 Төслийн ярилцлагад өгсөн үнэлгээ танилцуулах
- 9 Шалгалтын нэгдсэн дүн гаргах, танилцуулах
- 10 Хуралдааны шийдвэрийн төсөл танилцуулах

Шийдвэрлэсэн нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс гарсан шийдвэрийн дагуу БОЭТ-ийн Гүйцэтгэх удирдлагын багт үүрэг чиглэл өгөх тухай албан бичиг төлөвлөн хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Сумъяад үүрэг болгосугай.
2. Гүйцэтгэх удирдлагын албан тушаалд сонгогдсон нэр дэвшигчийн эрүүл мэндийн дүгнэлт, гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байгаагүй талаар цагдаагийн лавлагаа гаргуулж, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг албан бичгээр холбогдох байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулахыг нарийн бичгийн дарга Л.Сумъяад үүрэг болгосугай.
3. Гүйцэтгэх удирдлагын албан тушаалд томилогдох эмнэлгийн захиралтай байгуулах гэрээний төсөл боловсруулахыг ТУЗ-ийн гишүүн Б.Одончимэгт даалгасугай.
4. Захирлын сонгон шалгаруулалтын дүн болон ТУЗ-ийн ээлжит хуралдааны талаар мэдээллийг БОЭТ-ийн цахим хуудсанд ил тод байршуулахыг нарийн бичгийн дарга Л.Сумъяад үүрэг болгосугай.
5. Сонгон шалгаруулалттай холбоотой шалгалтын материалыг холбогдох журмын дагуу архивлан хадгалахыг нарийн бичгийн дарга Л.Сумъяад үүрэг болгосугай.

